



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 4 (433)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

- *Нийгмийн халамжийн тухай*
- *Ахмад настны нийгмийн хамгааллын тухай*
- *Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот

2006 оны нэгдүгээр сарын 28

№4 (433)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

48.	Нийгмийн халамжийн тухай (шинэчилсэн найруулга)	77
49.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	84
50.	Ахмад настны нийгмийн хамгааллын тухай (шинэчилсэн найруулга)	85
51.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	87
52.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай (шинэчилсэн найруулга)	87
53.	Хууль хүчингүй болсонд тооцох тухай	91
54.	Нийгмийн халамжийн тухай хуулиудыг дагаж мөрдөх журмын тухай	91
55.	Төрийн бэлгэ, тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	91
56.	Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	92

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

57.	Нийгмийн халамжийн тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 77	93
58.	Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай	Дугаар 01	93
59.	Тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 03	95
60.	Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай	Дугаар 04	95
61.	Хуулийн төслүүдийг буцаах тухай	Дугаар 05	95
62.	Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай	Дугаар 09	96
63.	Санхүүгийн зохицуулах хороо, түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох тухай	Дугаар 10	96
64.	Үнэт цаасны хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 11	96

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ (шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний төрөл,

хамрах хүрээг тогтоож, нийгмийн халамжийн санг бүрдүүлэх, зарцуулах журам, нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо, чиг үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж

2.1. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. мөрдөж буй хууль тогтоомж, журам, зааврын дагуу нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан иргэнд нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, тэдгээрийг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулахад чиглэсэн нийгмийн хамгааллын арга хэмжээг "нийгмийн халамж" гэнэ;

3.1.2. тэжээн тэтгэх төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхэд болон ядуу, нэн ядуу амьдралтай олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийг "нийгмийн эмзэг бүлэг" гэнэ;

3.1.3. Үндэсний статистикийн газар, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан аргачлалын дагуу судлахад ядуу, нэн ядуу амьдралтай болох нь тогтоогдож, түүнийг нь Амьжиргааг дэмжих зөвлөл баталсан бол тухайн өрх, иргэнийг "ядуу, нэн ядуу өрх, иргэн" гэж тооцно;

3.1.4. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүүхдийг "хүнд нөхцөлд байгаа хүүхэд" гэнэ;

3.1.5. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг "ахмад настан" гэнэ;

3.1.6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэнэ;

3.1.7. ядуу, нэн ядуу иргэний нэн тэргүүний хэрэгцээг хангах, амьжиргааг нь дэмжих зорилгоор тодорхой шалгуур, болзолтойгоор олгох мөнгөн тусламжийг "нөхцөлт мөнгөн тэтгэмж" гэнэ;

3.1.8. хувь хүн, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн оролцотойгоор нийгмийн эмзэг бүлгийн нэн тэргүүний хэрэгцээг тодорхойлох, хангах, амьжиргааг дээшлүүлэх, дэмжин туслах, сэргээн засах үйлчилгээг "олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ" гэнэ;

3.1.9. асран хамгаалах, харгалзан дэмжих төрөл, садангүй бөгөөд бие даан амьдрах чадваргүй, ганц бие, байнгын эмчилгээ, асаргаа шаардагдах ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэн түүнчлэн хүнд нөхцөлд байгаа хүүхдийг байршуулан хоол, хувцас, эмнэлэг, соёл, ахуй, сэтгэл зүй, асаргаа сувилахуйн үйлчилгээ үзүүлэх, тэдний амьдралын хэвийн нөхцөлийг бүрдүүлэх, хууль ёсны эрх ашгийг хууль тогтоомжид заасны дагуу хамгаалах үйл ажиллагааг "төрөлжсөн асрамжийн үйлчилгээ" гэнэ.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн хамрах хүрээ

4.1. Хууль тогтоомжид заасан болзол, шалгуур, нөхцөлийг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байгаа оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй.

4.2. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэн /дайн, байлдаан, зэвсэгт тулгаралтад оролцоноос бусад/-д нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг олгохгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Нийгмийн халамжийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн асуудал эрхлэх байгууллага

5.1. Нийгмийн халамжийн асуудлыг улсын хэмжээнд нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт тухайн шатны Засаг дарга тус тусын эрх хэмжээний хүрээнд эрхэлнэ.

6 дугаар зүйл. Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо

6.1. Нийгмийн халамжийн байгууллагын тогтолцоо нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн ажилтнаас бүрдэнэ.

6.2. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэх чиг үүрэгтэй агентлаг байна.

6.3. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргыг Төсвийн

байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 45.1-д заасны дагуу нэр дэвшүүлсэн хүмүүсээс сонгож нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар, аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын даргыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.4. Сум, хорооны нийгмийн ажилтныг тухайн аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын даргатай зөвшилцөн сум, дүүргийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

6.5. Сум, хороонд нийгмийн үйлчилгээний төв ажиллуулж болно.

6.6. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас тогтоон олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээг аймаг, дүүргийн халамж үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн үйлчилгээний төв, нийгмийн ажилтан гүйцэтгэнэ.

7 дугаар зүйл. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

7.1. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.1.2. халамжийн сан бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

7.1.3. халамжийн сангаас тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.4. нийгмийн халамжийн байгууллагын үйл ажиллагааны арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлах;

7.1.5. халамжийн болон асрамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах, тэдгээрт мэргэжил, арга зүйн туслалцаа, дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах;

7.1.6. доод шатны байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

7.1.7. нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах;

7.1.8. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг сурталчлах;

7.1.9. олон улсын болон гадаад орны ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах.

7.1.10. энэ хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөх санал боловсруулж, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад оруулах;

7.1.11. шаардлагатай тохиолдолд аймаг, дүүргийн нийгмийн халамжийн сангийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлж нэгдсэн журмаар хуваарилан зарцуулах;

7.1.12. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.9-д заасны дагуу журам, заавар боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

7.1.13. аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын албан тушаалтны гаргасан хууль бус шийдвэрийг өөрчлөх буюу хүчингүй болгох;

7.1.14. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээ, судалгаа, бусад холбогдох баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

8 дугаар зүйл. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний зохион байгуулалт

8.1. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээг улс, бус, орон нутгийн асрамжийн газар, нийгмийн халамжийн үйлчилгээг аймаг, дүүргийн халамж үйлчилгээний байгууллага, сум, хорооны нийгмийн үйлчилгээний төв, нийгмийн ажилтан тус тус үзүүлнэ.

8.2. Нийгмийн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээний байгууллагын үлгэрчилсэн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.3. Иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага нийгмийн халамж, асрамжийн үйл ажиллагаа эрхэлж болно.

8.4. Энэ хуулийн 8.3-т заасан иргэн, байгууллага нь нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамрагдсан байх бөгөөд тэдгээрийн зардлын зарим хэсгийг орон нутгийн төсөв, халамжийн сангаас гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

9 дүгээр зүйл. Амьжиргааг дэмжих зөвлөл

9.1. Нөхцөлт мөнгөн тэтгэмж, нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлох үүрэг бүхий

Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөл сум, хороонд ажиллана.

9.2. Энэ хуулийн 9.1-д заасан Зөвлөл нь сум, хорооны нутгийн захиргаа, иргэний нийгмийн төлөөллөөс бүрдсэн байна.

9.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Засаг даргын санал болгосноор сум, хорооны Хурлын Тэргүүлэгчид батална.

9.4. Зөвлөлийн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10 дугаар зүйл. Нийгмийн ажилтан

10.1. Нийгмийн ажилтны боловсрол эзэмшсэн, нийгмийн хамгааллын ажлын дадлага, туршлагатай, тухайн ажлыг мэргэжлийн түвшинд эрхлэх чадвартай, эрх бүхий байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн, мэргэшсэн нийгмийн ажилтан нийгмийн ажлыг гүйцэтгэнэ.

10.2. Мэргэшсэн нийгмийн ажилтан бэлтгэх тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийг магадлан итгэмжлэх, ажил үйлчилгээ явуулах эрх олгох ажиллагааг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

10.3. Нийгмийн ажилтан дор дурдсан үүрэг хүлээнэ:

10.3.1. орон нутгийн нийгмийн эмзэг бүлгийн болон ядуу өрх, иргэдийн тоон болон хэрэгцээний судалгаа гаргах;

10.3.2. нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж, шийдвэрлүүлэх;

10.3.3. нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хүсэл зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

10.3.4. нийгмийн эмзэг бүлэг, ядуу, нэн ядуу өрх иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхитай болоход нь зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах;

10.3.5. орон нутгийн төрийн болон төрийн бус байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хамтран ажиллах;

10.3.6. нийгмийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх;

10.3.7. нийгмийн ажилтанд хандсан хувь хүний /хууль зөрчсөнөөс бусад тохиолдолд/ нууцыг чандлан хадгалах;

10.3.8. нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж, журам, зааврыг сахин биелүүлэх.

10.4. Нийгмийн ажилтан дор дурдсан эрх эдэлнэ:

10.4.1. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх байгууллага, иргэнийг сонгоход оролцох, үйл ажиллагаа, үйлчилгээнийх нь чанарт хяналт, үнэлгээ хийх;

10.4.2. шаардлагатай мэдээ, судалгаа болон холбогдох баримт бичгийг тухайн байгууллагаас үнэ төлбөргүй гаргуулан авах;

10.4.3. нийгмийн халамжийн хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн бусад баримттай холбогдсон тайлбар, лавлагаа гаргуулж авах;

10.4.4. мэргэжлийн ёс зүй, эрх, үүрэгт нь болон үйлчлүүлэгчид харш үйлдэл гүйцэтгэхээс татгалзах;

10.4.5. олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйл ажиллагаанд орон нутгийн байгууллага, иргэнийг татан оролцуулах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Нийгмийн халамжийн сан

11 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн сан, түүний бүтэц

11.1. Нийгмийн халамжийн сан /цаашид "халамжийн сан" гэх/ нь мөнгөн хөрөнгийн сан байна.

11.2. Халамжийн сан дор дурдсан төрөлтэй байна:

11.2.1. тэтгэврийн сан;

11.2.2. амьжиргааг дэмжих сан.

11.3. Халамжийн сангийн дүрмийг Засгийн газар батална.

12 дугаар зүйл. Халамжийн сангийн орлогын эх үүсвэр

12.1. Халамжийн сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

12.1.1. төсвөөс олгох хөрөнгө;

12.1.2. сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

12.1.3. олон улсын байгууллага, гадаад орнуудаас өгсөн хандив, тусламж;

12.1.4. аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс өгсөн хандив, тусламж;

12.1.5. бусад эх үүсвэр.

12.2. Халамжийн сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

13 дугаар зүйл. Халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт

13.1. Тэтгэврийн сангийн хөрөнгийг нийгмийн халамжийн тэтгэвэрт зарцуулна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Нийгмийн халамжийн тэтгэвэр

13.2. Амьжиргааг дэмжих сангийн хөрөнгийг дараахь тэтгэмж, хөнгөлөлт, тусламж, үйлчилгээг санхүүжүүлэхэд зарцуулна:

- 13.2.1. нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- 13.2.2. нийгмийн эмзэг бүлгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламж;
- 13.2.3. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- 13.2.4. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- 13.2.5. нийгмийн даатгалын сангаас оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй нэн ядуу, ганц бие ахмад настны оршуулгын зардал.

13.3. Халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгө

14.1. Халамжийн санд улсын төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг харгалзан жил бүрийн Төсвийн тухай хуулиар тогтооно.

15 дугаар зүйл. Халамжийн сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах

15.1. Халамжийн сан тус бүрийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргаж тайлагнана:

15.1.1. улирлын тайланг аймаг, дүүргийн нийгмийн халамж үйлчилгээний байгууллага тухайн улирлын дараа сарын 25-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор тус тус гаргаж нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ;

15.1.2. нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь сангийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 20-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор тус тус гаргаж санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

15.2. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сангийн жилийн эцсийн тайлан тэнцлийг хянан хэлэлцэж, дүгнэлт гаргана.

16 дугаар зүйл. Халамжийн сангийн бүртгэл, тайлангийн маягтыг батлах

16.1. Халамжийн сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүүгийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

17 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэврийн төрөл

17.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр дараахь төрөлтэй байна:

- 17.1.1. ахмад настны халамжийн тэтгэвэр;
- 17.1.2. хөгжлийн бэрхшээлтэй иргэний халамжийн тэтгэвэр;
- 17.1.3. дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/-ийн халамжийн тэтгэвэр.

18 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх

18.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дор дурдсан иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй:

- 18.1.1. тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй;
- 18.1.2. хууль ёсны тэжээн тэтгэн нь ахмад настан, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй иргэн бөгөөд тэдгээр нь дэмжлэг туслалцаа үзүүлэх боломжгүй нь тогтоогдсон бол нэн ядуу амьдралтай 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй;
- 18.1.3. бүрэн хараагүй, хэлгүй, дүлий, одой иргэн;
- 18.1.4. энэ хуулийн 18.1.3-т зааснаас бусад хөдөлмөрийн чадвараа 70 ба түүнээс дээш хувиар алдсан, бие даан амьдрах чадваргүй хөгжлийн бэрхшээлтэй иргэн;
- 18.1.5. 16 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, нэн ядуу амьдралтай өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг.

ТАВДУГААР БҮЛЭГ

Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ

19 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийн төрөл

19.1. Нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж дараахь төрөлтэй байна:

- 19.1.1. жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж;
- 19.1.2. ахмад настныг асарч буй иргэнд олгох тэтгэмж;
- 19.1.3. хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох тэтгэмж;

19.1.4. хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж.

20 дугаар зүйл. Жирэмсэн болон нярай, хохуул хүүхэдтэй эхэд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж

20.1.Дор дурдсан эх жирэмсний 5 сартайгаас эхлэн нийт 12 сарын хугацаанд нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй:

20.1.1.ядуу, нэн ядуу амьдралтай өрхийн гишүүн;

20.1.2.нийгмийн даатгалын сангаас олгох жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүсээгүй.

21 дүгээр зүйл. Ахмад настныг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж

21.1.Асрамжинд байгаа ахмад настан нь эмч, эмнэлгийн байнгын хяналтад байдаг бөгөөд бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүй, нэн ядуу амьдралтай бол түүнийг асарч буй иргэн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй.

22 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд олгох нөхцөлт мөнгөн тэтгэмж

22.1.Асрамжинд байгаа хөгжлийн бэрхшээлтэй иргэн эмч, эмнэлгийн байнгын хяналтад байдаг бөгөөд бусдын асрамжгүйгээр бие даан амьдрах чадваргүй, нэн ядуу амьдралтай бол түүнийг асарч буй иргэн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй.

23 дугаар зүйл. Хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж

22.1. 0-18 хүртэл насны хүүхэдтэй, хүүхэд нь гэртээ хүмүүжиж байгаа ядуу, нэн ядуу амьдралтай өрхийн эх /эцэг, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч/ сар тутам хүүхдийн нөхцөлт мөнгөн тэтгэмж авах эрхтэй.

24 дүгээр зүйл. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээ, олгох журам

24.1. Энэ хуулийн 17 дугаар зүйлд заасан нийгмийн халамжийн тэтгэвэр, 19 дүгээр зүйлд заасан нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн жилийн амьжиргааны доод түвшинг харгалзан Улсын Их Хурал тогтооно.

24.2.Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох журмыг Засгийн газар батална.

24.3.Нийгмийн халамжийн сангаас олгох нөхцөлт мөнгөн тэтгэмжийг давхардуулан олгохгүй бөгөөд хэрэв давхардвал энэ хуулийн 19.1-д заасан тэтгэмжээс аль нэгийг иргэн өөрөө сонгох эрхтэй.

25 дугаар зүйл. Нийгмийн эмзэг бүлгийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн төрөл

25.1.Нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх хөнгөлөлт, тусламж дараахь төрөлтэй байна:

25.1.1.амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж;

25.1.2.нэн ядуу иргэнд орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад нь жилд нэг удаа олгох мөнгөн тусламж;

25.1.3.халамжийн цэцэрлэгийн үнийн хөнгөлөлт;

25.1.4.протез, ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслэлийн хангамж;

25.1.5.сэргээн засах үйлчилгээний зардлын хөнгөлөлт;

25.1.6.эх орны рашаан сувиллын зардлын хөнгөлөлт.

26 дугаар зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ

26.1.Олон нийтийн оролцоонд түшиглэсэн эмзэг бүлгийн халамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

26.1.1.амьдралын итгэл үнэмшил, хөдөлмөрийн дадал олгох, авьяасыг нь дэмжих зорилгоор зөвлөлгөө өгөх, сургалт зохион байгуулах;

26.1.2.зохион байгуулалттайгаар хөдөлмөр эрхлүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох зэргээр ядуурлаас гарахад нь туслах, энэ чиглэлээр хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдэд зуучлан хамруулах;

26.1.3.сэргээн засах үйлчилгээнд хамруулах;

26.1.4.түр байрлуулан асрамжлах;

26.1.5.гэрийн асрамж, халамжийн үйлчилгээнд хамруулах.

26.2. Энэ хуулийн 26.1-д заасан үйлчилгээнд ядуу, нэн ядуу амьдралтай дор дурдсан иргэн, өрхийг хамруулна:

26.2.1.ахмад настан;

26.2.2.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

26.2.3.хүнд нөхцөлд байгаа хүүхэд;

26.2.4.хүчирхийлэлд ертсөн иргэн;

26.2.5.нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн.

26.3.Энэ хуулийн 25.1.2, 25.1.4, 25.1.5, 25.1.6- д заасан хөнгөлөлт, тусламжид ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 25.1.1-д заасан тусламжид халамжийн тэтгэвэр, тэтгэмж нь зогсоогдсон эмзэг бүлгийн иргэн, 25.1.3-т заасан

хөнгөлөлтөд хүнд нөхцөлд байгаа хүүхэд, 26.1.5-д заасан үйлчилгээнд 26.2.1.- 26.2.4-т заасан иргэдийг тус тус хамруулж болно.

27 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тусламж, хөнгөлөлтийн хэмжээ

27.1. Нийгмийн эмзэг бүлэгт хамрагдсан өрх, иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, үйлчилгээ үзүүлэх журмыг Засгийн газар батална.

27.2. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний стандартыг Стандартчиллын төв байгууллага батална.

28 дугаар зүйл. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээ

28.1. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээ дараахь төрөлтэй байна:

28.1.1. ахмад настны асрамжийн;
28.1.2. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэний асрамжийн;
28.1.3. хүнд нөхцөлд байгаа хүүхдийн асрамжийн.

28.2. Энэ хуулийн 28.1-д заасан үйлчилгээнд дор дурдсан иргэн хамрагдана:

28.2.1. тэжээн тэтгэх хүүхэд, төрөл, садангүй, бие даан амьдрах чадваргүй ганц бие, эсхүл тэжээн тэтгэх үүрэгтэй этгээд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх чадваргүй болох нь тогтоогдсон бөгөөд олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдах боломжгүй ахмад настан;

28.2.2. мэргэжлийн үйлчилгээ, тусгай нөхцөл шаардагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн;

28.2.3. хүнд нөхцөлд байгаа, эсхүл байнгын асрамжид байдаг хөгжлийн бэрхшээлтэй 16 хүртэлх насны хүүхэд.

29 дүгээр зүйл. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргах

29.1. Өрх, иргэнийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг Амьжиргааг дэмжих зөвлөлийн, төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг нийгмийн халамж үйлчилгээний байгууллагын саналыг тус тус үндэслэн аймаг, дүүргийн Засаг дарга гаргана.

30 дугаар зүйл. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний зардлын хэмжээ

30.1. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 6.2-т

заасан байгууллагын саналыг үндэслэн төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэний дор дурдсан зардлын норматив, эд хөрөнгийн эдэлгээний хугацаа, журмыг баталж мөрдүүлнэ:

30.1.1. хоол хүнс, хувцас, эм, ариун цэвэр, хичээлийн хэрэглээний нэг хүнд ногдох зардлын норматив, хувцас, хичээлийн хэрэглээний эдэлгээний хугацаа;

30.1.2. нас барсан иргэнийг оршуулах зардлын норматив;

30.1.3. үйлчилгээ үзүүлэх журам.

30.2. Төрөлжсөн асрамжийн үйлчилгээний стандартыг Стандартчиллын төв байгууллага батална.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох

31 дүгээр зүйл. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

31.1. Энэ хуульд заасан нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж авах шаардлагыг хангасан иргэн өргөдөл гаргах эрхтэй.

31.2. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгох иргэн холбогдох баримт бичгийг бүрдүүлж, өргөдлийн хамт сум, дүүргийн нийгмийн халамжийн байгууллага, эсхүл нийгмийн ажилтанд өгнө.

31.3. Энэ хуулийн 31.2-т заасан байгууллага, албан тушаалтан халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгох өргөдлийг хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

31.4. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгох иргэний бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

32 дугаар зүйл. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох

32.1. Нийгмийн халамжийн байгууллага энэ хуулийн 31.1-д заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг банкаар дамжуулан сар бүр олгоно.

32.2. Тэтгэвэр, тэтгэмж авагч өөрөө хүсэлт гаргавал улирлын тэтгэвэр, тэтгэмжийг дараа улирлын эхний сард бөөнөөр нь олгож болно.

32.3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас өөрийн биеэр тэтгэвэр, тэтгэмжээ авах боломжгүй иргэний тэтгэвэр, тэтгэмжийг түүний итгэмжлэгдсэн

хүнд, эсхүл нийгмийн халамжийн байгууллага өөрт нь шууд олгож болно.

32.4. 16-гаас доош насны, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд олгох тэтгэвэрийг эцэг, эх, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигчид нь олгоно.

32.5. Нийгмийн халамжийн байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг түүнийг авах эрх бүхий хүний хүсэлтээр хадгаламжийн дансанд нь шилжүүлж болно.

33 дугаар зүйл. Халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг зогсоох, түүнээс суутгал хийх

33.1. Хуурамч бичиг баримт бүрдүүлж халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж тогтоолгон авсан нь тогтоогдвол түүний олголтыг зогсооно.

33.2. Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлснээс илүү олгогдсон тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийг нөхөн төлүүлэх тухай шүүхийн, эсхүл улсын байцаагчийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

33.3. Энэ хуулийн 33.2-т заасан суутгалын хэмжээ нь сарын тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн 50 хувиас хэтэрч болохгүй.

33.4. Энэ хуулийн 33.2-т зааснаас бусад тохиолдолд тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжээс суутгал хийхийг хориглоно.

33.5. Нийгмийн халамжийн байгууллага, ажилтны гаргасан алдаанаас илүү олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг буцаан суутгахгүй бөгөөд хохирлыг шүүхийн журмаар буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж болно.

34 дүгээр зүйл. Тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөх

34.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг тухайн жилийн амьжиргааны доод түвшингийн хэмжээтэй уялдуулан Улсын Их Хурал өөрчлөн тогтооно.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

35 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

35.1. Хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон, түүнчлэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

35.2. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, халамжийн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдах иргэний тодорхойлолтыг үндэслэлгүйгээр болон хуурамчаар үйлдсэн албан тушаалтан, нийгмийн ажилтныг улсын байцаагч 1000-60000 төгрөгөөр торгоно.

35.3. Хөдөлмөрийн чадвар алдсан шалтгаан, хувь хэмжээ, хугацааг үндэслэлгүйгээр буюу хуурамчаар тогтоосон албан тушаалтныг Хөдөлмөрийн тухай хуулийн 141.1.17-д заасны дагуу торгож, олгогдсон тэтгэвэр, тэтгэмж, үйлчилгээний зардлыг хууль тогтоомжид заасны дагуу нөхөн төлүүлнэ.

35.4. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, эсхүл хувийн зорилгод ашиглах зэргээр хууль тогтоомж зөрчсөн нийгмийн ажилтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

халамжийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Нийгмийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

АХМАД НАСТНЫ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ */Шинэчилсэн найруулга/*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь ахмад настанд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний төрөл, хэмжээг тогтоож, төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын энэ талаар хүлээх эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж

2.1. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хууль үйлчлэх хүрээ

3.1. 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй Монгол Улсын иргэн энэ хуульд хамрагдана.

3.2. Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг энэ хуулийн 3.1-д заасан насанд хүрсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг энэ хуульд хамруулж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ахмад настны нийгмийн хамгаалал

4 дүгээр зүйл. Нийгмийн хамгааллын арга хэмжээ

4.1. Ахмад настныг нийгмийн хамгааллын дараахь арга хэмжээнд хамруулж болно:

- 4.1.1. нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- 4.1.2. нийгмийн халамжийн тэтгэвэр;
- 4.1.3. нөхцөлт мөнгөн тэтгэмж;

- 4.1.4. тусламж, хөнгөлөлт;
- 4.1.5. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- 4.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- 4.1.7. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- 4.1.8. эрүүл мэндийн үйлчилгээ.

4.2. Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, түүнчлэн төрийн өндөр албан тушаал эрхэлж байсан ахмад настанд улсын тусгай тэтгэвэр тогтоох нөхцөл, журмыг хуулиар тогтоож болно.

5 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

5.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан ахмад настанд дор дурдсан хөнгөлөлт, тусламж үзүүлж болно:

5.1.1. хөл, гар, шүд (үнэт металаар хийхээс бусад)-ний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл дотоодод хийлгэх нэг удаагийн зардал олгох;

5.1.2. ахмадын зориулалттай амралт, сувилалын газарт амрах эрхийн бичгийг хөнгөлөлттэй үнээр олгох;

5.1.3. нэн ядуу амьдралтай ахмад настан орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад жилд нэг удаа мөнгөн тусламж олгох;

5.1.4. нэн ядуу амьдралтай, түүнчлэн хүндэт донор ахмад настан эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр дотоодын рашаан сувилалд амарч сувилуулах тохиолдолд тээврийн хэрэгслийн нэг талын зардал, эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.5. нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсээгүй, нэн ядуу, ганц бие ахмад настан нас барвал оршуулгын зардлын 75 хувийг нийгмийн даатгалын сангаас олгох;

5.1.6. нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл (таксианаас бусад)-ээр Авто тээврийн тухай² хуулийн 12.2-т заасны дагуу үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр зорчих;

5.1.7. худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газар тэргүүн эзлжид үйлчлэх;

¹ Монгол Улсын Үндсэн хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

² Авто тээврийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

5.1.8.Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын цолтон, ахмад дайчин, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдсэн иргэний эхнэр/нөхөр/-т улирал бүр мөнгөн тусламж үзүүлэх;

5.1.9.Монгол Улсын гавьяат болон төрийн соёрхолт, түүнчлэн Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, "Эхийн алдар" нэг, хоёрдугаар зэргийн одонтой ахмад настанд жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх;

5.1.10.Монгол Улсын болон Хөдөлмөрийн баатар, ардын цолтон гавьяат цолтон, төрийн соёрхолт, ахмад дайчин, Улсын ударник, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд энэ хуулийн 5.1.8-5.1.9-д зааснаас гадна дор дурдсан хөнгөлөлтийг үзүүлнэ.

5.1.10.1.нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа олгох;

5.1.10.2.дотоодын рашаан сувилалд ирэх, буцах замын зардал, эрхийн бичгийн үнийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.10.3.орон сууцны хөлс төлөх, түлээ, нүүрс худалдан авахад нь жилд нэг удаа мөнгөн тусламж үзүүлэх.

5.2.Ахмад настанд үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, тэдгээрийг олгох журмыг Засгийн газар батална.

6 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл

6.1.Жил бүрийн билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгэн болон бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага ажиллаж байсан ахмад настандаа хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулна.

6.2.Билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгнийг тохиолдуулан тухайн нутаг дэвсгэрийн хамгийн өндөр настанд аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын, 100 ба түүнээс дээш настай ахмад настанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ, гарын бэлэг тус тус гардуулна.

6.3.Ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан буюу татан буугдсан, түүнчлэн өөр орон нутгаас шилжиж ирснээс хэргэялах байгууллага, аж ахуйн нэгж байхгүй болсон ахмад настныг орон нутгийн захиргаа, нийгмийн халамжийн болон ахмад настны байгууллага билгийн тооллын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгэн болон бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлнэ.

7 дугаар зүйл. Тусламж, хөнгөлөлтийг санхүүжүүлэх эх үүсвэр

7.1.Энэ хуулийн 5.1.1-5.1.6-д заасан тусламж, хөнгөлөлтийг нийгмийн халамжийн амьжиргааг дэмжих сангаас, 5.1.8-5.1.10-т заасан тусламж, хөнгөлөлтийг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Ахмад настны нийгмийн хамгааллын талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг

8 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны хүлээх үүрэг

8.1.Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ахмад настны нийгмийн хамгааллыг сайжруулах, нийгмийн даатгал, халамжийн сан болон улсын төсвөөс олгох тэтгэвэр, тэтгэмж, тусламжийг нэмэгдүүлэх талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулах, энэ талаар гарсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж биелэлтийг хангах үүрэг хүлээнэ.

8.2.Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ахмад настны талаархи хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулж, тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлах, нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах үүрэг хүлээнэ.

8.3.Бүх шатны Засаг дарга ахмад настны нийгмийн хамгааллын талаар тус тусын эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээнэ:

8.3.1.баг, хорооны Засаг дарга ахмад настанг судалж бүртгэх, хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж тогтоох болон тусламж үзүүлэхэд шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд нь дэмжлэг үзүүлж үнэн зөв тодорхойлолт гаргаж өгөх;

8.3.2.сум, дүүргийн Засаг дарга ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, ахмад настанг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах талаар эрх бүхий байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, ахмад настанг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийг нь хамгаалах, ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь татан буугдсан буюу өөр орон нутгаас шилжин ирсэн ахмад настныг бүртгэж, нийгмийн хамгааллын арга хэмжээнд хамруулах;

8.3.3.аймаг, нийслэлийн Засаг дарга ахмад настны нийгмийн хамгааллын талаар

авах арга хэмжээ, зарцуулах төсвийн санал боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, энэ талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах, ахмад настанг төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамруулах саналыг халамжийн байгууллагад уламжлах;

8.3.4. ахмад настны кабинет, төв байгуулж ажиллуулах, энэ арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах.

8.4. Аж ахуйн нэгж, байгууллага ажиллаж байсан ахмад настанд нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж, түлээ, нүүрс олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, орон сууцтай болоход нь дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авна.

8.5. Энэ хуулийн 8.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулан аж ахуйн нэгж, байгууллага бүр цалингийнхаа нийт сангийн 3 хүртэл хувиар "Ахмадын сан" байгуулна.

8.6. Ахмад настны ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг шилжүүлэн авсан этгээд энэ хуулийн 8.4-т заасан үүргийг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл. Ахмадын байгууллага

9.1. Ахмад настны олонхийн нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах төв байгууллагыг улсын төсвөөс, орон нутгийн байгууллагыг тухайн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

9.2. Ахмадуудын санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсдын 70-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад Засгийн газар болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлж болно.

9.3. Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг ахмад настны төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж төсөл, арга хэмжээний зардлыг санхүүжүүлж болно.

10 дугаар зүйл. Ахмад настны тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

10.1. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 12 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Ахмад настны

нийгмийн хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУХАЙ

(шинэчилсэн найруулга)

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх нийгмийн хамгааллын үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтоох, энэ талаар иргэн, хуулийн этгээдийн

хүлээх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж

2.1. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль¹. Нийгмийн халамжийн тухай хууль,

¹ Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Төрөлхийн болон удамшлын эмгэг өөрчлөлт, эсхүл осол, гэмтлийн улмаас сэтгэг, окуун ухаан, мэдрэхүйн чадавхи нь алдагдсан, түүнчлэн бие эрхтэн нь гэмтсэнээс хөдөлмөрлөх, бие даан амьдрах боломж нь хязгаарлагдсан хүнийг "хөгжлийн бэрхшээлтэй иргэн" гэж ойлгоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгаалал

4 дүгээр зүйл. Нийгмийн хамгааллын арга хэмжээ

4.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийгмийн хамгааллын дараахь үйлчилгээнд хамрагдах эрхтэй:

- 4.1.1. нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж;
- 4.1.2. нийгмийн халамжийн тэтгэвэр;
- 4.1.3. нөхцөлт мөнгөн тэтгэмж;
- 4.1.4. тусламж, хөнгөлөлт;
- 4.1.5. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ;
- 4.1.6. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- 4.1.7. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;
- 4.1.8. эрүүл мэндийн үйлчилгээ;
- 4.1.9. боловсрол, соёл, урлагийн үйлчилгээ.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж, хөнгөлөлт

5.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд нийгмийн халамжийн сангаас дор дурдсан тусламж, хөнгөлөлтийг үзүүлнэ:

- 5.1.1. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, нэн ядуу амьдралтай өрхөд орон сууцны хөлс төлөх, түлээ нүүрс худалдан авахад нь жилд нэг удаа олгох мөнгөн тусламж;
- 5.1.2. 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дотоодод хийлгэсэн протезийн үнийг хоёр удаа 100 хувь нөхөн олгох;

5.1.3. нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн протезийн үнийг эхний удаа 100 хувь, хоёр дахь удаа 50 хувь нөхөн олгох;

5.1.4. ядуу амьдралтай өрхийн 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, түүнчлэн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авах эрх үүсээгүй, ядуу амьдралтай өрхийн хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгох;

5.1.5. харах, сонсох, ярих боломж нь хязгаарлагдмал сурагч болон түүний асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн тусгай сургуульд ирж, очих унааны зардлыг жилд нэг удаа хөнгөлөх;

5.1.6. нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэн дотоодын рашаан сувилалд сувилуулбал эрхийн бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгох;

5.1.7. нэн ядуу амьдралтай өрхийн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан иргэний 4 хүртэлх насны нэг хүүхдийн цэцэрлэгийн хоолны зардлын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх;

5.1.8. ядуу амьдралтай, хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй, насанд хүрсэн бүрэн хараагүй иргэнтэй өрхийн суурин телефон утасны төлбөрт хөнгөлөлт үзүүлэх.

5.2. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксианаас бусад/-ээр Авто тээврийн тухай² хуулийн 12.2-т заасны дагуу үнэ төлбөргүй буюу хөнгөлөлттэй үнээр зорчино.

5.3. Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэнд тэргүүн ээлжинд үйлчилнэ.

5.4. Энэ хуулийн 5.1-д заасан тусламж, хөнгөлөлтийн хэмжээ, олгох журмыг Засгийн газар батална.

5.5. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төрөлжсөн асрамжийн, эсхүл олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулж болно.

6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний бие эрхтэний сэргээн засалт

6.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн нийгмийн амьдрал идэвхтэй оролцох, чийрэгжих, өөрөө өөртөө үйлчилж сурах, хөдөлмөрлөх чадвартай болох зорилгоор үйл ажиллагаа нь алдагдсан эрхтэнээ сэргээх.

² Авто тээврийн тухай хууль - "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

солиулах ээргээр сэргээн засах эмчилгээ, үйлчилгээнд хамрагдах эрхтэй.

6.2.Сэргээн засах эмчилгээ, үйлчилгээг эмчилгээ сувилгаа, сургалт, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага эрхэлж болно.

7 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний сурах, боловсрол эзэмших эрх

7.1.Сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үед байгаагаас бусад тохиолдолд энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн эрүүл иргэдтэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмших эрхтэй.

7.2.Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, боловсрох, мэргэжил эзэмших чадвартай энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг энэ хуулийн 7.1-д зааснаас бусад үндэслэлээр элсүүлэхээс, элсэлтийн шалгалтад оруулахаас татгалзахыг хориглоно.

7.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан хүүхэд энэ хуулийн 7.1-д заасан шалтгаангүй бол сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагад эрүүл хүүхэдтэй хамт хүмүүжих эрхтэй.

7.4.Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг элсүүлэх хөнгөлөлттэй нөхцөл бүрдүүлж, тэнцсэн тохиолдолд тухайн иргэний, түүнчлэн хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралч буюу окуутны сургалтын зардлыг сургалтын төрийн сан хариуцна.

7.5.Тусгай хэрэгцээт боловсрол олгох ясли, цэцэрлэг, бүх шатны сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд суралцах энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тодорхойлно.

7.6.Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллага нь энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний боломжид үндэслэн стандартын дагуу боловсрол эзэмшүүнэ.

7.7.Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллагаар батлуулна.

7.8.Тусгай хэрэгцээт боловсрол олгох сургалтын байгууллагын гүйцэтгэх албан

тушаалтанд үндсэн цалингийн 10-30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл хөлс олгоно.

7.9.Хөгжлийн бэрхшээлтэй иргэн тусгай хэрэгцээт боловсролд үнэ төлбөргүй хамрагдахыг төрөөс дэмжинэ.

7.10.Энэ хуулийн 7.4, 7.9-д заасан сургалтын зардлын хэмжээ, 7.8-д заасан нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

8 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлт

8.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэн ажил, хөдөлмөр эрхлэхэд нь дэмжлэг үзүүлж түүний ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт эдлүүлнэ.

8.2.Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, энэ хуулийн 7.1-д зааснаас бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг хориглоно.

8.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний ажлын цагийг Хөдөлмөрийн тухай³ хуулийн 71.5-д заасны дагуу богиносгож болно.

9 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ

9.1.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг олон улсын болон өөрийн оронд зохиогддог соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд идэвхтэй оролцоход нь төрөөс дэмжинэ.

9.2.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд зориулсан соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээ нь түүний чадавхид зохицсон байна.

9.3.Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнд зориулсан дор дурдсан арга хэмжээг төрийн зохих байгууллага зохион байгуулна:

9.3.1. ажил, амьдралынх нь талаар

олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

9.3.2. телевизийн мэдээллийн нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулгатай гаргах;

9.3.3. нийтийн тээврийн хэрэгсэл, төмөр зам, орон сууц, албан байгууллага, нийтийн үйлчилгээний газрын орц, гарц, гэрэлтүүлэг, бие засах газрын зорчих хэсгийг эдгээр иргэдийн хязгаарлагдмал боломжид тохируулан хийх;

9.3.4. гэрлэн дохио, нийтийн үзвэр, үйлчилгээний газрын талбай, зам, харилцаа, холбооны хэрэгсэл эдгээр иргэдийн хэрэгцээ, шаардлагад зохицсон байх.

³ Хөдөлмөрийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

9.3.5. аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид эдгээр иргэдийн соёл, урлаг, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд санхүүгийн туслалцаа үзүүлэх;

9.3.6. нийгмийн амьдралд идэвхтэй оролцож, дорвитой хувь нэмэр оруулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон эдгээр иргэдийн нийгмийн хамгааллын талаар хүлээсэн үүргээ сайн биелүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжих.

10 дугаар зүйл. Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг тогтоох, үнэмлэх олгох, статистик мэдээлэл гаргах

10.1. Иргэн хөгжлийн бэрхшээлтэй болохыг нь түүний оршин суугаа аймаг, дүүргийн эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.

10.2. Эмнэлэг-хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрийг үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар бүртгэж үнэмлэх олгоно.

10.3. Энэ хуулийн 10.2-т заасан үнэмлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно.

10.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаархи статистик мэдээллийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар гаргаж, Үндэсний статистикийн газарт өгнө.

10.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний үнэмлэхийн загвар, түүнийг олгох журмыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, албан ёсны статистик мэдээллийн маягтыг Үндэсний статистикийн газрын дарга батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн

хамгааллын талаархи аж ахуйн нэгж,

байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

11 дүгээр зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

11.1. Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаархи төрийн бодлого боловсруулах холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

11.2. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаархи хууль тогтоомжийн биелэлтийг хангаж тэтгэвэр, тэтгэмж, тусламж, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх арга хэлбэрийг боловсруулж болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлах, нийгмийн халамжийн үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь

уялдуулан зохицуулах, тэдгээрт дэмжлэг, туслалцаа үзүүлэх арга хэмжээ авна.

11.3. Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын талаар тус тусын эрх хэмжээний хүрээнд дор дурдсан үүрэг хүлээнэ:

11.3.1. сум, дүүрэг, хорооны Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран зохион байгуулах, энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэнийг нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах, эсхүл уг асуудлаар дээд шатны байгууллагад санал тавьж шийдвэрлүүлэх, сургалтад хамруулах, урлаг соёл, биеийн тамир, олон нийтийн арга хэмжээнд оролцуулах;

11.3.2. аймаг, нийслэлийн Засаг дарга хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын асуудлаар орон нутгийн хэмжээнд авах арга хэмжээний санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, энэ талаар баримтлах хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах.

11.4. Аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад хөгжлийн бэрхшээлтэй болсон иргэнд тухайн байгууллага тусламж, дэмжлэг үзүүлнэ.

11.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх, үүргийг хүлээж авсан этгээд энэ хуулийн 11.4-т заасан үүргийг хэрэгжүүлнэ.

12 дугаар зүйл. Төрийн зохих байгууллагын зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх

12.1. Энэ хуульд заасан төрийн болон нутгийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж, зардлыг гэрээний үндсэн дээр санхүүжүүлж болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад асуудал

13 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

13.1. Энэ хуулийн 3 дугаар зүйлд заасан иргэний нийгмийн хамгааллын тухай хууль тогтоомж зөрчсөн гэм буруутай этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

13.2. Иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг буруу тогтоож тэтгэвэр, тэтгэмж, эсхүл үүсгэсэн албан тушаалтанд Нийгмийн халамжийн тухай хуулийн 35.2-т заасны дагуу хариуцлага хүлээлгэж, олгогдсон тэтгэвэр, тэтгэмжийг нөхөн төлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА ЦНЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1995 оны 12 дугаар сарын 19-ний өдөр батлагдсан Төхир дутуу хүний нийгмийн хамгааллын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр батлагдсан Хөгжлийн

бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2005 оны 12 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ ХУУЛИУДЫГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг 2006 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. 1998 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу тэтгэвэр авч байгаа иргэний нийгмийн халамжийн тэтгэврийг түүний насанд хүрэх болон хөдөлмөрийн чадвар

нь сэргээгдэх, эсхүл нас барах хүртэлх хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 14¹ дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8 дахь заалт тус тус нэмсүгэй:

1/14¹ дүгээр зүйл:

"14¹ дүгээр зүйл. Төрийн далбааг дурсгах

1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд өөрийн албан тасалгаанд байрлуулсан төрийн далбааг төр, нийгмийн өмнө гавьяа байгуулсан иргэн, хуулийн этгээдэд дурсгал болгон хадгалуулахаар хүндэтгэлтэйгээр гардуулан өгч болно."

2/ 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7, 8 дахь заалт:

"7/ бүх шатны боловсролын байгууллагын хичээлийн шинэ жилийн нээлтийн ажиллагаа эхлэхэд;

8/хуульд өөрөөр заагаагүй бол тангараг өргөдөг төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа төгсөхөд."

2 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "бүх шатны" гэсний өмнө "Удсын Их Хурлын

гишүүн, Засгийн газрын гишүүн," Дөрөвдүгээр бүлгийн гарчгийн "...байрлуулах" гэсний дараа ", дурсгах", 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Төрийн тугийг" гэсний дараа "цэнгүүлэх,", 25 дугаар зүйлийн "Иргэд," гэсний дараа "өрх," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.Үндэсний их баяр наадмын өмнөх өдрүүдэд Төрийн тугийг цэнгүүлж, баяр наадмын өдөр баяр наадмын төв талбайд хүндэтгэн зална."

4 дүгээр зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтын дугаарыг "9" гэж, 22 дугаар зүйлийн "хүн босож" гэснийг "иргэд босож, дуулж" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2006 оны 1 дүгээр сарын 05-ны өдөр

Улаанбаатар хот

ЭМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эмийн тухай хуульд дор дурдсан агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16,17 дахь заалт:

"3.1.16. "эмнэлгийн хэрэгсэл" гэж хүн, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх, сувилах болон бие махбодийн бүтэц, үйл ажиллагааг дэмжих зорилгоор ашиглагддаг туслах зориулалтын эд зүйлийг;

3.1.17. "эмийн гаж нөлөө" гэж хүн, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг оношлох, эмчлэх зорилгоор зохист тунгаар хэрэглэхэд бие махбодид гарч байгаа хортой, сөрөг илэрлийг."

2/4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:

"4.5. Энэ хуулийн 4.3-т заасан жагсаалтад орсон эмийн үнийг Засгийн газраас зохицуулж болно."

3/ 7 дугаар зүйлийн 5,6,7 дахь хэсэг:

"7.5. Эм хангамжийн байгууллага нь улсын стандартын шаардлагыг хангасан байна.

7.6. Эм хангамжийн байгууллага нь ашиг орлогоо нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтнийг эм, эмнэлгийн хэрэгсэл борлуулах, үр дүнгээр нь урамшуулах буюу түүнтэй адилтгах үйл ажиллагаанд оролцуулахыг хориглоно.

7.7. Хуурамч эм импортлох, үйлдвэрлэх, худалдахыг хориглоно."

4/ 8 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"8.8. "Монгол Улсад үйлдвэрлэв" гэсэн шошго, стандартын дугаартай эм, эмнэлгийн хэрэгслийг импортлохыг хориглоно."

5/ 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"13.6. Малын эмч нь эмийн сан, түүний салбараас худалдан авсан малын эм, эмнэлгийн хэрэгслээр мал, амьтан бүхий иргэнд үйлчилж болно."

6/ 16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"16.4. Энэ хуулийн 16.2-т заасан фармакопей болон бусад норматив-техникийн баримт бичгийг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална."

7/ 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 6 дахь заалт:

"17.3.6. эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахад урамшуулал олгох буюу тэдгээрийн үнийг хямдруулсан тухай сурталчлах."

8/ 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"17.4. Эмийн гаж нөлөөг бүртгэж, мэдээлэх журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална."

9/ 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"19.1.8. Энэ хуулийн 7.7-г зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол эм болон хууль бусаар олсон орлогыг хурааж, эерчил гаргасан иргэнийг 40000-50000, албан тушаалтныг 50000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 200000-250000 төгрөгөөр торгох ба үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 2 жил хүртэл хугацаагаар хүчингүй болгох."

2 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "биобэлдмэл /цаашид "эм" гэх/ гэсний дараа "эмнэлгийн хэрэгсэл" гэж, 6.1.2, 8.2, 8.3, 18.3, түүнчлэн 18 дугаар зүйлийн гарчиг дахь "эм" гэсний дараа "эмнэлгийн хэрэгсэл" гэж, 6.3-ын "тов" гэсний дараа "болон мэргэжлийн" гэж, 8.7, 13.2-ын "эрүүл мэндийн" гэсний дараа "болон хөдөө аж ахуйн" гэж, 19.1.1-ийн "7.2.2" гэсний дараа "7.5" гэж, "зөрчсөн бол" гэсний дараа "албан тушаалтныг 10000-20000," гэж, 19.1.5-ын "зөрчил гаргасан" гэсний дараа "албан тушаалтныг 20000-25000," гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн дараахь хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт:

"3.1.10. "хуурамч эм" гэж хууль бусаар ашиг олох зорилгоор эм үйлдвэрлэгчийн нэрээр хуурамч шошго хэрэглэж, дууриалган үйлдвэрлэсэн эмийн бүтээгдэхүүнийг."

2/ 8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5. Эм, эмнэлгийн хэрэгсэл импортлогч нь гадаадын эмийн үйлдвэр, эсхүл түүний гэрээт борлууллагчтай гэрээ байгуулсан байна."

3/ 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"13.4. Багийн хүний эмч эмийн сан, түүний салбараас худалдан авсан эм, эмнэлгийн хэрэгслээр үйлчлэх хүрээнийхээ хүн амд үйлчилж болно."

4/ 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"15.2. Эмийн улсын бүртгэлд эм бүртгүүлэх, бүртгэлийн төлбөр, түүнийг зарцуулах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус тус батална."

4 дүгээр зүйл. Эмийн тухай хуулийн нэрийг "Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай" гэж, мөн хуулийн 2.1, 4.3, 5.3.2, 6.1.1, 7.2.2, 8.4, 10.1, 10.2, 10.2.6, 11.1, 16.1, 16.2, түүнчлэн 2.10.11, 16 дугаар зүйлийн гарчиг дахь "эмийн" гэснийг "эм, эмнэлгийн хэрэгслийн" гэж, 7.1, 13.1, 13.3, 14.1.1-ийн "эмээр" гэснийг "эм, эмнэлгийн хэрэгслээр" гэж, 6.3-ын "эмэнд" гэснийг "эм, эмнэлгийн хэрэгсэлд" гэж, 5.3.3, 6.2, 7.3, 7.4, 8.4, 14.1.2, 14.1.6, түүнчлэн 8 дугаар зүйлийн гарчиг дахь "эмийг" гэснийг "эм, эмнэлгийн хэрэгслийг" гэж, 7.2.3-ын "эмийн нөөц, нийлүүлэлт, борлуулалтыг" гэснийг "эм, эмнэлгийн

хэрэгслийн нөөц, хангамж, үйлчилгээг" гэж; 8.6-ын "Тусгай зөвшөөрлийн бичигт эм, бэлдмэлийн нэр" гэснийг "Импортын зөвшөөрлийн бичигт эм, эмнэлгийн хэрэгслийн нэр, тоо" гэж, 8.7-ын "импортолно" гэснийг "импортолж болно" гэж, 3.1.12, 16¹.1, 16².2, 17.3.3, 19.1, түүнчлэн 16¹ дүгээр зүйлийн гарчиг дахь "сэтгэц" гэснийг "сэтгэцэд" гэж, 5.3.4, 11.1.3-ын "сэтгэц нөлөөт" гэснийг "сэтгэцэд нөлөөт" гэж, 19.1.2-ын "8.1, 8.3-ыг зөрчсөн бол эм" гэснийг "энэ хуулийн 7.6, 8.1, 8.3, 8.8-ийг зөрчсөн бол эм, эмнэлгийн хэрэгсэл" гэж, 18.1-ийн "түүхий эдийг бүртгэх" гэснийг "түүхий эд, эмнэлгийн хэрэгсэлд" гэж, гуравдугаар бүлгийн гарчгийг

"Эмийн улсын бүртгэл, эм, эмнэлгийн хэрэгслийн чанарын баталгаа, хяналт, мэдээлэл, сурталчилгаа" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 8.4 дэх хэсгийн "чанарын баталгаажуулалт"; 11.1, 2 дахь заалтын "дууриамал болон" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 3.1.11 дэх заалт, 18.4 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2005 оны 12 дугаар сарын 08—ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар хот

Нийгмийн халамжийн тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

1/ Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудад Засгийн газраас батлахаар заасан журам, зааврыг 2006 оны 6 дугаар сарын 1-ний дотор батлан гаргаж, мөрдүүлэх;

2/ Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу олгох тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоох саналаа 2007 онд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/ Нийгмийн эмзэг бүлгийн амжиргаанд дэмжлэг үзүүлэх тусламж, хөнгөлөлтийн хэмжээг амжиргааны доод түвшинг харгалзан шинэчлэн тогтоох арга хэмжээг улсын төсвийн хуульд жил бүр тусгах замаар хэрэгжүүлэх;

4/ Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулиудыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангах зохион байгуулалтын болон тэдгээрийг нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг авах, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх сургалтыг бүсчилэн зохион байгуулах.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 05—ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү бодлогыг Монгол Улсын хөгжлийн ойрын болон дунд хугацааны төлөвлөгөө, Мянгань

хөгжлийн зорилттой уялдуулан жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ц.Элбэгдорж/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ**

Монгол Улсын Их Хурлын 2006 оны 01 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРӨӨС АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын олон хэвшил бүхий эдийн засгийн онцлог, Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Зохистой хөдөлмөрийн үзэл баримтлал", "Хөдөлмөрийн хүрэн дэх суурь зарчим ба үндсэн эрхүүдийн тухай Тунхаглал"-ын

үзэл санаанд тулгуурлан төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогыг (цаашид "бодлого" гэнэ) үндэсний хэмжээнд тодорхойлж, хэрэгжүүлнэ.

1.2. Энэ бодлогын зорилго нь албан бус хөдөлмөр эрхлэгчдийг төрийн үйлчилгээгээр

дамжуулан албан хэлбэрт шилжүүлэх, аливаа эрсдэлээс хамгаалах эрх зүй, эдийн засаг, хөдөлмөр, нийгмийн хамгааллын баталгаа бий болгож, улс орны эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэхэд оршино.

1.3. Албан бус хөдөлмөр эрхлэлт гэдэгт албан ёсны бүртгэл, мэдээлэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, хөдөө аж ахуйн бус, аж ахуй эрхлэх аливаа нэгэн зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээг хувь хүн, өрх, хамтлаг эрхлэхийг хамруулна.

1.4. Бодлогогч Монгол Улсын хөгжлийн ойрын болон дунд хугацааны төлөвлөгөө, Мянганы хөгжлийн зорилттой уялдуулан, улс орны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган, бодлогын нэгдүгээр үеийг 2006-2008 онд, хоёрдугаар үеийг 2009-2011 онд, гуравдугаар үеийг 2012-2015 онд тус тус хэрэгжүүлнэ.

Хоёр. Баримтлах зарчим

2.1. Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд аливаа дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно.

2.2. Хувь хүн, өрх, хамтлагийн аж ахуй эрхлэх эрх, эрх чөлөөг хүндэтгэнэ.

2.3. Албан бус хөдөлмөр эрхлэлтээс албан хэлбэрт шилжих санаачилга, үйл ажиллагааг дэмжинэ.

2.4. Нийгмийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлана.

2.5. Ажлын байр нэмэгдүүлэх, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх эдийн засгийн бодлоготой охсоулна.

2.6. Албадан болон хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр, нийгэм, эдийн засгийн талаар ялгаварлан гадуурхах явдлыг устгах зорилттой уялдуулна.

2.7. Албан бус хөдөлмөр эрхлэгчдэд үзүүлэх үйлчилгээ, дэмжлэг нь тэдний үйл ажиллагааны хэлбэр, бус нутгийн онцлогоос үл хамааран тэгш, хүртээмжтэй байна.

Гурав. Хэрэгжүүлэх арга зам

3.1. Албан бус хөдөлмөр эрхлэлтийг макро эдийн засгийн бодлоготой уялдуулж, газрын шинэчлэл, хөрөнгө оруулалт, технологийн, татвар, санхүү, зээл, бүртгэл, мэдээллийн бодлогоор дамжуулан зохион байгуулалтад орох боломжийг өргөжүүлнэ. Энэ зорилгоор:

3.1.1. хувь хүн, өрх, хамтлагийн ажил, үйлчилгээ эрхлэх, хөдөлмөрөө оновчтой хорших, үйл ажиллагаагаа албан хэлбэрт шилжүүлэх сонирхлыг газар эзэмших, ашиглах, өмчлөх бодлогоор дэмжиж;

3.1.2. зээлийн үйлчилгээний төрлийг өргөжүүлэх, зээл авах боломжийг нэмэгдүүлэх замаар хувь хүн, өрх, хамтлагийн хадгаламж, хуримтлалаа өсгөх сонирхлыг бий болгож;

3.1.3. эд хөрөнгийн болон зээлийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлж, албан бус

хөдөлмөр эрхлэгчдийн хөрөнгийг эрсдэлээс хамгаалах;

3.1.4. татварын уян хатан бодлогоор дамжуулан хувь хүн, өрх, хамтлагийн ажил, үйлчилгээгээ албан хэлбэрт шилжүүлэх боломжийг дээшлүүлэх;

3.1.5. нийгмийн даатгалын хувь хэмжээг үе шаттайгаар бууруулах, цалин, хөлсний тогтолцоог боловсронгуй болгох замаар албан хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх;

3.1.6. албан бус хөдөлмөр эрхлэлтийг үндэсний статистикийн бүртгэл, тооцооны системд хамруулж, мэдээлэл, судалгааг боловсронгуй болгож;

3.1.7. албан бус хөдөлмөр эрхлэгчдийг техник, технологийн дэвшил, хөрөнгө оруулалтаар дэмжиж, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтарч ажиллах боломжийг бүрдүүлэх.

3.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчныг сайжруулан энэхүү хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрлөх эрхийн баталгааг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн хангахад анхаарна. Энэ зорилгоор:

3.2.1. хөдөлмөрийн хууль тогтоомжийн хамрах хүрээг өргөжүүлэн, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг албан хөдөлмөр эрхлэгчдийн нэг эдлэл хөгжүүлэхэд чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлэх;

3.2.2. албан бус хөдөлмөр эрхлэгчдэд ажил, үйлчилгээний чиглэл болон бизнесийн сонирхлоороо нэгдэх, төлөөллөө бий болгоход нь дэмжлэг үзүүлэх;

3.2.3. хөдөлмөрийн хяналтын чиг үүрэг, хүртээмжийг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн өргөжүүлж, хөдөлмөрийн харилцааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

3.2.4. өндөр эрсдэлтэй ажил, үйлчилгээ эрхэлж байгаа албан бус хөдөлмөр эрхлэгчдийг зохион байгуулалтын оновчтой хэлбэрт оруулах чиглэлтэй эрх зүйн орчин бүрдүүлэх.

3.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлоготой уялдуулан албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогын тогтвортой эх үүсвэр бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжинэ. Энэ зорилгоор:

3.3.1. хөдөлмөр эрхлэлтийн олон хэв шинж, бус нутгийн онцлогт нийцсэн уян хатан бодлого хэрэгжүүлэх;

3.3.2. хөдөлмөр эрхлэлтийн талаархи төсөл, тусламжид ахмад настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулах;

3.3.3. албан бус хөдөлмөр эрхлэгчдэд аж ахуй эрхлэх үр чадвар олгох, түүнийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг сайжруулж, нийгмийн эмзэг хэсгийг түлхүү хамруулах арга хэлбэрийг дэмжиж;

3.3.4. албан бус хөдөлмөр эрхлэгчид мэдээлэл, харилцааны технологийг

ашиглан зах зээлийн талаархи шинэ мэдлэг олж авах боломжийг бүрдүүлэхэд анхаарах;

3.3.5. бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн үйлдвэрлэл, худалдаа, зуучлалыг өргөжүүлж, бизнесийн үйлчилгээний төрөл, хэлбэрийг хөгжүүлэх.

3.4. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн нөхцөл, ашиг сонирхол, орлогын байдалтай уялдуулан тэдгээрийн нийгмийн хамгааллыг сайжруулна. Энэ зорилгоор:

3.4.1. албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хөдөлмөрийн нөхцөлийг үе шаттай сайжруулахад чиглэсэн менежментийг нэвтрүүлж, энэ чиглэлээр Олон улсын хөдөлмөрийн байгууллагын техник, арга зүйн дэмжлэг авах;

3.4.2. нийгмийн даатгалын үйлчлэх хүрээ, нэр төрлийг өргөжүүлж, тэдгээрт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамруулах талаар төсөл боловсруулж хэрэгжүүлэх;

3.4.3. албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалын талаархи мэдлэгийг дээшлүүлж, тэдэнд үзүүлэх үйлчилгээний чанарыг сайжруулах;

3.4.4. албан бус хөдөлмөр эрхлэгчдийг олон улсын жишигт нийцсэн нийгмийн хамгааллын сайн дурын бүтэц, бичил сүлжээнд хамруулах талаар гарч байгаа санал, санаачилгыг дэмжих.

3.5. Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн хамтын ажиллагааг хөгжүүлэн албан бус хөдөлмөр эрхлэлтийг албан хэлбэрт шилжүүлэхэд нийгмийн түншлэлийн болон олон нийтийн үүрэг оролцоог нэмэгдүүлж, тэдний чадавхийг бэхжүүлнэ. Энэ зорилгоор:

3.5.1. албан бус хөдөлмөр эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах талаар ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн болон бусад байгууллагаас гаргаж байгаа санаачилгыг дэмжих;

3.5.2. нийгмийн зөвшлийг хангах гурван талт хэлэлцээр, үндэсний хороо, зөвлөл зэрэг хамтын ажиллагааны хэлбэрт албан бус хөдөлмөр эрхлэгчдийг оролцуулах боломжийг бүрдүүлэх;

3.5.3. албан бус хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох, тэдгээрт үндэсний хууль тогтоомжийн нийцүүлэх арга хэмжээ авах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, тарифын бус бусад хязгаарлалт тогтоох бүлэг барааны жагсаалтыг батлах тухай Монгол Улсын

Их Хурлын 1998 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 3 дахь хэсгийн "Хаягдал хар болон өнгөт төмөрлөг" гэсний өмнө "Пиво, ундааны хаягдал лаазнаас бусад" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаас гаргахыг зөвшөөрөх тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улирлын чанартай мөнгөн хөрөнгийн дутагдлыг нөхөх зорилгоор 2006 оны төсвийн жилд

80.0 хүртэлх тэрбум төгрөгийн үнэт цаас гаргаж, нийтэд санал болгон арилжаалахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хуулийн төслүүдийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3 дахь хэсгийн заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалайн 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын тухай

хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул төсөл санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6, Засгийн газрын тухай хуулийн 4 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхий сайдаар Миеэгомбын Энхболдыг томилсугай.

2. Энэ тогтоолыг 2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Санхүүгийн зохицуулах хороо, түүний дэргэдэх Хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11.2, 29.2 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Дашдоржийн Бадраа, орон тооны гишүүнээр Бадрахын Шаравсамбуу, Даш-Онолтын Дүгэржав, орон тооны бус гишүүнээр Наваансамдангийн Ганбямба, Батаагийн Ганболд, Бядрангийн Лхагвасүрэн, Дондийн Цэрэнжамц нарыг тус тус томилсугай.

2. Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлийн даргаар Рэгзээгийн Амарсайхан, гишүүнээр Отгонсүрэнгийн Батчулуун, Лувсандоржийн Дашдорж, Лайлангийн Тунгалаг, Гаравдэмбэрэлийн Хэрлэн нарыг тус тус томилсугай.

3. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

Үнэт цаасны хорооны дарга, гишүүнээс чөлөөлөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 29.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, гишүүд томилогдсонтой холбогдуулж Содномцэрэнгийн Гүндэнбалыг Үнэт цаасны хорооны дарга, Сээтэрийн Хүгүдэр, Сэнцэлдоржийн

Жамъянсүрэн, Бядрангийн Лхагвасүрэн, Намжилдоржийн Энхбаяр нарыг тус хорооны гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2. Энэ тогтоолыг 2006 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Ц.НЯМДОРЖ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн зөвлөл.

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Улаанбаатар-12
Төрийн ордон

☎ 265958
Индекс 14003

☎ 329487
Хэвлэлийн хуудас 2.5

